



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2024.11.06 № 31

Төрийн хэмнэлтийн хуулийн  
хэрэгжилтийн талаар

Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын дараах Монгол Улсын эдийн засгийг сэргээх, төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавих зорилгоор Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 онд баталж, мөрдүүлсэн. Энэ хуулийн хүрээнд олон үр дүнтэй ажлууд хийгдэж үр дүнд үзүүлсэн ч зарим ажлууд нэр төдий хийгдэж, хуулийн зорилго, зорилтыг бүрэн хангаж чадахгүй байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Хуулийн 7.3-т “Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална” гэж заасны дагуу уг нийтлэг жишиг батлагдсан эсэх, төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга хэрэгсэлд хэрхэн хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг хангасан талаар;
2. Хуулийн 8.1, 8.2-т заасан төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглосон заалтын хэрэгжилтийн талаар;
3. Хуулийн 10.1-д “Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, .... тогтооно” гэж заасны дагуу уг нийтлэг жишиг батлагдсан эсэх, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсөд хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангасан талаар;
4. Хуулийн 14 дүгээр зүйл буюу Цахим худалдан авалтын хэрэгжилтийн талаар;


2024000056

5. Хуулийн 15 дугаар зүйл буюу Хэмнэлтийн бусад арга хэмжээний хэрэгжилтийн талаар;
6. Хуулийн 15.2 заасан Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлууд, гарсан үр дүн тоо, чанараар, нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулсан эсэх, тоолуурын тоо, гарсан үр дүн тоо, чанараар;
7. Хуулийн 17 дугаар зүйл буюу Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар;
8. Хуулийн 20.2-т “Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулах бөгөөд тэдгээрийн ажлын байранд тавих шаардлага, сонгон шалгаруулалтад оролцсон этгээд, сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, томилсон шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна” гэж заасны дагуу хэчнээн гүйцэтгэх захирал, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулсан, сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, томилсон шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулсан талаар зэрэг болно.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан хугацаанд ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



О.ЦОГТГЭРЭЛ

2024000056